



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/656

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ерөнхий прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх Б.Ганбаатар өөр аймагт томилогдон ажиллах болсон тул гэр бүлийн уналга, ачаа тээш, тээврийн шатахууны зардал, “Макс групп”-ын ерөнхийлөгч Д.Ганбаатар Монгол Улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн баатар” цол тэмдгээр шагнагдсан тул дурсгалын зүйлээр шагнах зардлыг тус тус шийдвэрлэсүгэй.

2. Шаардагдах 1900000 (Нэг сая есөн зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ